



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 4/52

Хужирт сум

Г Сумын онцгой комиссын бүрэлдэхүүн,
ажиллах журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22.3 заалтыг Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 11 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Улсын онцгой комиссын ажиллах журам”-ын 1.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Онцгой комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх хор уршгийг арилгах, аврах, хойшлуулашгүй сэргээн босгох арга хэмжээнд онцгой комисс ажиллах журам болон энэ талаар даган мөрдөж байгаа бусад хууль тогтоомжуудтай нийцүүлж шуурхай зохион байгуулж ажиллахыг комисс, бие бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавиж ажиллахыг Онцгой комиссын орлогч дарга (Б.Дэмбэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМОНХ

Засаг даргын 2022 оны 03 дугаар
сарын 27-ны өдрийн 11:52 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

СУМЫН ОНЦГОЙ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга Т.Баярмөнх- Сумын Засаг дарга

Орлогч Б.Дэмбэрэл- Засаг даргын Орлогч

Нарийн бичгийн дарга: Б.Бямбасүрэн- Байгаль орчны хяналтын улсын
байцаагч

Гишүүд: 3.Цэцэгмаа- Засаг даргын Тамгын газрын дарга, мэргэжлийн ангийн
дарга

Д.Баянсан-Эрэн хайх, аврах бүлгийн ахлагч

Д.Уранчимэг-Санхүүгийн албаны дарга

Л.Цэдэв-Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн

Ц.Нямдорж-Газрын даамал

Т.Элбэгсайхан-Архив, бичиг хэргийн эрхлэгч

Д.Мөнхбат-Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн

Э.Оюунпүрэв-Сумын Эрүүл мэндийн төвийн дарга

А.Гантулга-Ерөнхий боловсролын Сургуулийн захирал

Х.Түмэнбаяр-Цагдаагийн тасгийн дарга

Ц.Тунгалаг- Цаг уурын станцын эрхлэгч

С.Цэрэндаваа-Эрчим хүчний станцын эрхлэгч

О.Долгормаа-Соёлын төвийн дарга

З.Оюунчимэг- 1 дүгээр Цэцэрлэгийн эрхлэгч

Ш.Эрдэнэхорол- 2 дугаар Цэцэрлэгийн эрхлэгч

Д.Норов- 3 дугаар Цэцэрлэгийн эрхлэгч

С.Батцэцэг- 4 дүгээр Цэцэрлэгийн эрхлэгч

Д.Дамдинготох-Холбооны дарга

Ш.Отгонбат- 1 дүгээр багийн Засаг дарга

С.Самдан- 2 дугаар багийн Засаг дарга

Т.Даваадорж – 3 дугаар багийн Засаг дарга

Д.Мягмарсүрэн- 4 дүгээр багийн Засаг дарга

Ц.Лхамролом- 5 дугаар багийн Засаг дарга

Ц.Амгалан- 6 дугаар багийн Засаг дарга

Сумын Засаг даргын 2022 оны
03..сарын 17..ны өдрийн 15 дугаар
захирамжийн 1 дугаар хавсралт

СУМЫН ОНЦГОЙ КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ:

1. Сумын Онцгой комисс /цаашид комисс/-оос гамшгаас хамгаалах тухай хуулинд заасан аюулт үзэгдэл, хүн малын гоц халдварт өвчин, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн аюулаас хүн ам, мал амьтан хүрээлэн байгаа орчныг аврах, хор уршгийг арилгах хойшлуулашгүй сэргээн босгох арга хэмжээ авах, түүнийг хэрэгжүүлэхэд төрийн захирагааны болон бусад баг, байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтны үйл ажиллагааг уялдуулан зохицуулах шуурхай зохион байгуулах, хяналт тавихад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

2. Комисс нь гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж энэ журмыг удирдлага болгон үйл ажиллагаагаа явуулна.

3. Сумын Онцгой комиссын бүрэлдэхүүнийг сумын Засаг дарга батална.

4. Сумын Онцгой комиссыг сумын Засаг дарга тэргүүлнэ. Комиссын даргын эзгүйд Засаг даргын орлогч ажиллана.

5. Комиссын хурал нийт гишүүдийн 60-аас доошгүй хувийн ирцтэй бол хүчин төгөлдөр болох бөгөөд хэлэлцсэн асуудлыг хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэж тэмдэглэл гаргана.

6. Комиссын дарга холбогдох хууль тогтоомж энэ журмаар олгогдсон үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар албан даалгавар гаргаж болно.

7. Комиссоос гаргасан шийдвэрийг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд, өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан дагаж мөрдөнө.

8. Комиссын өдөр тутмын үйл ажиллагааг сумын онцгой байдлын асуудал хариуцсан мэргэжлийн ангийн дарга эрхэлнэ.

ХОЁР.КОМИССЫН ЭРХ ҮҮРЭГ:

9. Комисс дараах үүрэгтэй байна.

1. Сумын Онцгой комисс нь нутаг дэвсгэртээ гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулашгүй сэргээн босгох арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх аймгийн онцгой комиссоос өгсөн үүрэг даалгаварын биелэлтийг хангах.

2. Гамшгийн голомтод аврах, хор уршгийг арилгах хойшлуулашгүй сэргээн босгох арга хэмжээг удирдан зохион байгуулах, эдгээр арга хэмжээнд оролцож байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах.

3. Гамшгийн цагийн байдлын үнэлгээг мэргэжлийн байгууллага, шинжээчээр хийлгэж өгсөн үнэлэлтийг комиссын хурлаараа хэлэлцэж шийдвэр гаргах.

4. Гамшиг бүх нутаг дэвсгэр, бүс нутгийн холбогдох байгууллага, аж ахуйн нэгжийг бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, хорио цээрийн дэглэм тогтоох талаар

санал боловсруулж Засаг даргад оруулан шийдвэрлүүлэх, хэрэгжүүлэх, мөрдүүлэх ажлыг зохион байгуулна.

5.гамшгийн голомтод ажиллагсадын ажиллах журмыг тухайн нөхцөл цагийн байдалтай уялдуулан тогтоон өгч хэрэгжилтийн явцад хяналт тавих.

6.Гамшгийн голомтод Засгийн газар, олон улсын хүмүүнлэгийн байгууллагаас болон аймаг орон нутгаас тусlamж хүргэх болон олгосон бараа материал, тусlamжийн зүйлс зохих журмын дагуу очиж байгаа эсэхэд хяналт тавих.

7.Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх аврах, хор уршгийг арилгах хойшлуулашгүй сэргээн босгох, нэрвэгсэдэд шуурхай тусlamж үзүүлэх нүүлгэн шилжүүлэх ажил шаардагдах хүн хүч, техник хэрэгслэлийг зохих журмын дагуу дайчлан гаргах асуудлыг төрийн захиргааны болон бусад байгууллага албан тушаалтантай хамтран шийдвэрлэх, зохицуулах, шаардлагатай гэж үзвэл нэмэгдэл хүн хүч, техник хэрэгсэл дайчлан гаргах санал боловсруулан шийдвэрлүүлэх.

8.Комиссоос болон нийтэд хүргэх анхааруулга, санамж болон авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар хэвлэл мэдээлэлийн хэрэгслээр шуурхай мэдээлж байх.

ГУРАВ.КОМИССЫН ЭРХ:

1.Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулашгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлаар баг байгууллага, аж ахуйн нэгжийн дарга нарт үүрэг даалгавар өгч ажиллах.

2.Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулашгүй сэргээн босгох арга хэмжээнд холбогдох төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллага, албан тушаалтан, гадаадын хөрөнгө оруулалттай болон дотоодын аж ахуйн нэгж, иргэдийг хууль тогтоомжийн дагуу өмчийн төрөл хэлбэр үл харгалзан татан оролцуулах.

3.Холбогдох байгууллага, албан тушаалтанаас шаардлагатай тайлан мэдээ, мэдээлэл, судалгаа гаргуулан авах, мэдээлэл илтгэлийг хэлэлцэн шийдвэр гарган биелэлтийг хангуулах.

4.Гамшгийн голомтод хэрэгжүүлж байгаа арга хэмжээг шалгаж дүгнэлт гаргах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах.

ДӨРӨВ.КОМИССЫН ЗАРДАЛ:

1.Комиссын тухайн үеийн үйл ажиллагааны зардлыг аймгийн онцгой комиссоос болон сумын онцгой байдлын штабаас гаргасан тооцоог үндэслэн Засаг даргын нөөц хөрөнгө бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

2.Сумын онцгой комисс нь нутаг дэвсгэртээ гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах хойшлуулашгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон зардлыг тухайн жилийн төсөвтөө тусган зориулалтын дагуу зарцуулна.

ТАВ.БУСАД:

1.Комисс нь ажлын тайлангаа жил бүрийн 1 дүгээр сард багтаан Засаг даргын дэргэдэх зөвлөлд танилцуулна.

2.Өгсөн үүрэг даалгавар биелүүлээгүй байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэнд захиргааны шийтгэл ноогдуулах саналаа эрх бүхий холбогдох байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлнэ.